# “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/*

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа* | 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: “Монгол шуудан” ХК<br>УБГД: 9012001026<br>ҮЦК: MNP, MN00MNP05412<br>Утас: (+976) 7007-8918, (+976) 11-330788<br>Хаяг: Сүхбаатарын талбай 1, Энхтайвны өргөн чөлөө, Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Улаанбаатар хот-15160, Монгол Улс |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 99,586,363 |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Улирлын тайланг бэлтгэсэн:<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ<br><br>Хянасан:<br>Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн |

1\. *Хагас жил болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

*Санхүүгийн байдлын үзүүлэлт*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2026.01.01) | Эцсийн үлдэгдэл (2026.06.30) |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| Эргэлтийн хөрөнгө | 19,409,328,297.39 | 32,685,766,366.22 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 16,148,013,507.74 | 18,989,019,902.52 |
| **Нийт хөрөнгө** | **35,557,341,805.13** | **51,674,786,268.74** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| Өр төлбөрийн нийт дүн | 9,702,632,327.66 | 22,218,742,230.19 |
| Эздийн өмч | 25,854,709,477.47 | 29,456,044,038.55 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **35,557,341,805.13** | **51,674,786,268.74** |

*Орлогын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2026.01.01) | Эцсийн үлдэгдэл (2026.06.30) |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | **25,423,475,974.10** | **21,176,868,986.30** |
| Борлуулалтын өртөг | 25,540,234,067.30 | 20,243,318,567.46 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 1,143,799,730.66 | 515,944,730.72 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 1,508,611,115.51 | 956,076,304.43 |
| Бусад | - | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **518,430,521.95** | **493,418,845.13** |
| **Орлогын татварын зардал** | 45,882,258.59 | 9,544,952.12 |
| **Татварын дараах ашиг** | **472,548,263.36** | **483,873,893.01** |

*Өмчийн өөрчлөлтийн тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2026.01.01) | Эцсийн үлдэгдэл (2026.06.30) |
|---|---|---|
| **Эздийн өмч** | **9,958,636,300.00** | **13,124,221,300.00** |
| **Хуримтлагдсан ашиг** | **6,263,555,660.64** | **6,699,305,221.72** |

<table>
<tr><td></td><td>Мөнгөн гүйлгээний тайлан</td><td><table>
<tr><th>Үзүүлэлт</th><th>Эхний үлдэгдэл (2026.01.01)</th><th>Эцсийн үлдэгдэл (2026.06.30)</th></tr>
<tr><td>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</td><td>(684,501,740.30)</td><td>(2,573,687,903.34)</td></tr>
<tr><td>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>(782,826,996.71)</td><td>126,433,318.68</td></tr>
<tr><td>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>(97,672,829.25)</td><td>(48,124,331.93)</td></tr>
</table></td></tr>
<tr><td colspan="3"></td></tr>
<tr><td>2.</td><td colspan="2">Хагас жил болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</td></tr>
<tr><td></td><td colspan="2">-</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="2">Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</td></tr>
<tr><td>3.1</td><td>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td><td>Цэвэр ашгийн хувь - 2.29%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж - 1.75%<br>Нийт хөрөнгийн өгөөж - 1.11%</td></tr>
<tr><td>3.2</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</td><td>Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа – 1.28%</td></tr>
<tr><td>3.3</td><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</td><td>Гадаад орчны нөлөөлөл:<br>• Цахимжилт, интернэтийн хөгжлөөс шалтгаалан бичиг захиа, хэвлэл захиалга зэрэг уламжлалт шуудангийн үйлчилгээний эрэлт буурч байна.<br>• Харин цахим худалдааны өсөлт нь шинэ боломжийг бий болгож байна<br>• Технологийн хөгжил, зах зээлийн өөрчлөлт нь уламжлалт дэд бүтцийг шинэчлэх, шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нэмэгдүүлж байна.<br>• Дэлхий дахинд хил дамнасан цахим худалдаа эрчимтэй хөгжиж байгаа нь олон улсын логистик, хүргэлтийн зах зээлд өрсөлдөх боломжийг бүрдүүлж байна.<br>• Валютын ханшийн хэлбэлзэл, төгрөгийн сулрал нь зардлыг өсгөж, ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.<br>• Зах зээл дэх өрсөлдөөн идэвхжиж, дотоодын болон гадаадын өрсөлдөгчдийн тоо нэмэгдсэнээр үнийн өрсөлдөөн ширүүсэж, ашигт ажиллагаанд нөлөөлөх эрсдэл үүсэж байна.<br>• Шатахууны хомсдол, үнийн өсөлт нь үйлчилгээний өртгийг нэмэгдүүлж, зардлын дарамтыг бий болгож байна.<br>• Ажиллах хүчний хомсдол, өндөр эргэлт нь үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйл болж байна.<br><br>Дээрх сорилтуудыг даван туулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ:<br>• Уламжлалт дэд бүтцийг орчин үеийн зах зээлийн шаардлагад нийцсэн, уян хатан, өндөр бүтээмжтэй дэд бүтэц болгон шинэчлэхэд хөрөнгө оруулж байна.<br>• Технологи, автоматжуулалтыг нэвтрүүлж, хүчний нөөцөөс хамаарах хамаарлыг бууруулж байна.<br>• Гадаад зэх зээлийг тэлж, валютын орлогыг нэмэгдүүлэх замаар ханшийн эрсдэл, зардлын өсөлтийг саармагжуулж байна.<br>• Цахим систем, платформ хөгжүүлэлтэд хөрөнгө оруулж, олон улсын цахим худалдааны платформуудтай интеграц хийж, шинэ үйлчилгээ нэвтрүүлж байна<br>• Мөнгөн урсгалын орлого, зардлын тогтвортой байдлыг хангах зорилгоор хэджинг (hedging) стратегийг хэрэгжүүлж байна.</td></tr>
<tr><td>3.4</td><td>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх</td><td>"Монгол шуудан" ХК-ийн санхүүгийн тайлан нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай"</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</td><td>хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС/IFRS)-ыг мөрдлөг болгон, бүртгэлийн аккруэль суурьт зарчимд үндэслэн төгрөгөөр үнэн зөв, бүрэн илэрхийлж бүртгэгддэг бөгөөд Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.</td></tr>
<tr><td>4.</td><td colspan="2">Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.<br>Сонирхлын зөрчилтэй хэлцэл:<br>1. Мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор компанийн таван зуун мянган ам долларыг 6 сарын хугацаатай хадгаламжид байршуулахыг зөвшөөрөв. ТУЗ-2026.03.26-26/08 (Ард Кредит ББСБ ХК)</td></tr>
<tr><td>5.</td><td colspan="2">Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээ</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</td></tr>
<tr><td>6.</td><td colspan="2">Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Хувьцаа эзэмшигчдийн бүтэц<br>
<br>НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО<br>99,586,363<br>НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО<br>3,438<br>(2026.04.03-ны өдрийн тархалтын мэдээгээр)<br><br>Хувьцаа эзэмшигчдийн хурал<br><br>Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “MSE HALL” хурлын танхимд 96.5 хувийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдав. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.<br>1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.<br>2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлав.<br><br>Хурлын дараах тайлан<br><br>Хуулийн хугацаанд буюу 2026.04.27-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал (144 хуудас хэвлэмэл материал, компанийн жилийн тайлан болон ХЭ-чдийн хурлын товхимол хэлбэрийн материал)-ыг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид тус тус хүргүүлэн тайлагнан ажиллав.<br><br>Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн<br><br>1. Даваахүү НАРАНГЭРЭЛ<br>Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга<br><br>2. Даваасамба ДЭЛГЭРМАА<br>Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга</td></tr>
</table>

3. **Даваадорж БАЛЖИННЯМ**
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн

4. **Хаш-Эрдэнэ СҮРЭНХОРОЛ**
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн

5. **Одончимэд ОДБАЯР**
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга

6. **Галнсям УЯНГА**
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

7. **Банзрагч ГАНБААТАР**
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

8. **Дарамбазар БАЛДОРЖ**
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

9. **Чүлтэм АМАРБААТАР**
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

**Компанийн бүтэц**

- ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 25/20 дугаар тогтоолоор компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлав. Энэ дагуу компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар зарим удирдах албан тушаалтнуудыг шинэчлэн томилов. Үүнд:
  - ✓ Марк, үнэт цаасны газрын захирлаар Б.Билгүүн, Санхүү, төлөвлөлтийн газрын захирлаар Б.Нарандулам
- Компанийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах хүрээнд ТУЗ-ийн 2026 оны 05 дугаар 28-ны өдрийн 26/14 дүгээр тогтоолоор компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлав.



| | |
|---|---|
| 7. | *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл* |

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээлэл**

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус 7 удаагийн хуралдаан (цахим, танхим, эчнээ)-аар 22 асуудлыг хэлэлцэж, 16 тогтоол, 4 тэмдэглэлээр шийдвэр гаргасан байна.

**Ногдол ашиг**

“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 26/02 дугаар тогтоолоор компанийн 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаарх цэвэр ашгийн дүнгээс 31.6 хувиар буюу нэгж хувьцаанд 1.5 төгрөгөөр тооцож ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэв.
Ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар ногдол ашгийг олгов. Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг компаниас шууд төлөх замаар олгов.

**Компанийн засаглалын кодексын хэрэгжилт**

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж” ийн дагуу компанийн “Компанийн засаглалын кодекс” ийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үнэлж, Санхүүгийн зохицуулах хорооонд хүргүүлсэн. Өөрийн үнэлгээний тайлангаар 72 онооноос 70 оноо буюу 97 хувь, “Хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

| № | Гарчиг | Авбал зохих оноо | Өөрийн үнэлгээгээр авсан оноо | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 11 | 92% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг, үүрэг | 10 | 10 | 100% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод байдал | 6 | 6 | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 7 | 88% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | 100% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 10 | 100% |
| | **Нэгдсэн дүн** | **72** | **70** | **97 %** |

**Мэдээллийн ил тод байдлын тайлагнал**

Тайлант хугацаанд дараах тайлан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржэд илгээн, хуулийн хугацаанд олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2025 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр),
- 2025 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (монгол, англи хэл дээр),
- 2025 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан,
- 2025 оны жилийн эцсийн байдлаарх Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн тайлан,
- 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал,
- 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан (монгол, англи хэл дээр),
- 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр),
- Тухай бүр хүргэх мэдээллүүд

| 8. | *Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл* |
|---|---|
| | Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаас үзнэ үү. |

*Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:*

| | |
|---|---|
| *Овог, нэр:* Г.Тэлмэн<br><br>*Албан тушаал:* "Монгол шуудан" ХК Гүйцэтгэх захирал<br><br>*Гарын үсэг:* ......................................<br><br>*(Тамга, тэмдэг)* | *Овог, нэр:* Б.Нарандулам<br><br>*Албан тушаал:* "Монгол шуудан" ХК Санхүү, төлөвлөлтийн газрын захирал<br><br>*Гарын үсэг:* ......................................<br><br>*(Тамга, тэмдэг)* |

*Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:*

*Овог, нэр:* Д.Цэцгээ

*Албан тушаал:* "Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

*Гарын үсэг:* ......................................

*Огноо:* 2026.07.27